

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 434 дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зогсоож, “Монголын төмөр зам” ТӨХК-д нэгтгэн зохион байгуулах, мөн өдрийн 435 дугаар тогтоолоор “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг үүрэг болгосон.

Монгол улсын Их хурлын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээий тухай” 73 дугаар тогтоолын 2 дахь заалтаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх таалаар шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх Монгол улсын Засгийн газарт үүрэг болгосон байна.

Дээрх Улсын Их хурлын тогтоолын хэрэгжилтийн хангах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг цуцалж, тус зөвшөөрлийг 5 жилийн хугацаатайгаар “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосон.

Улмаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “Компани үүсгэн байгуулах тухай” 12 дугаар хурлын тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх коцессыг тусгаарлаж, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Зорилго нь: “төслийн удирдлагын үйл ажиллагаанаас-төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ үзүүлдэг” компани болох.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 27 дугаар тогтоолыг үндэслэн Гүйцэтгэх захирлын “Компаний орон тооны зохион байгуулалт, албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээ батлах тухай” 2022 оны А/09 дүгээр тушаалыг баталсан.

Үйл ажиллагааны тайлан

Компани нь Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, 5 газрын дарга, 23 хэлтэстэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 304 дүгэр тогтоолоор “Тавантогой төмөр зам” ХХК-ийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр тогтоож, “Тавантолгой төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр тогтоож, “Тавантолгой төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулагдсан.